МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 10 өдөр Дугаар А/22 Улаанбаатар хот

**Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө” батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ын 2.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар батлсугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, агентлаг, байгууллагын дарга нарт даалгасугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд /С.Баатаржав/-д үүрэг болгосугай.

Х.НЯМБААТАР

1119287523 ШТТ6740 9131817

Doc\tushaal Said. 2021

151600202

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
А/22 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

# ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ “2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ”

2021 ОН

## ГАРЧИГ


НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .......................................................................................................3-8

ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ .......................................................................................................9-10

ГУРАВ.АЛСЫН ХАРАА .......................................................................................................11

ДӨРӨВ.ЭРХЭМ ЗОРИЛГО .......................................................................................................11

ТАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ .......................................................................................................12-14

ЗУРГАА.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО .......................................................................................................15-16

ДОЛОО.СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ .......................................................................................................17-36

НАЙМ.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ .......................................................................................................37

ЕС.ХАВСРАЛТ .......................................................................................................38




УХА0577
9131817
1116126371

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| ЗГХЭГ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ЗХХАХБХ | Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэс |
| ЭЗХ | Эрх зүйн хэлтэс |
| ХОТХ | Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтэс |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ХХЕГ | Хил хамгаалах ерөнхий газар |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| АЕГ | Архивын ерөнхий газар |
| ГИХГ | Гадаадын иргэн, харьяатын газар |
| ШШҮХ | Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн |
| ДХИС | Дотоод хэргийн их сургууль |
| ХЗҮХ | Хууль зүйн үндэсний хүрээлэн |
| ХЗТТ | Хууль зүйн туслалцааны төв |
| ТТАХНЭ | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг |
| ОӨГ | Оюуны өмчийн газар |
| МУГХУСАЗЗ | Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл |
| МХХ | Монголын хуульчдын холбоо |
| МНТ | Монголын нотариатчдын танхим |
| МӨХ | Монголын өмгөөлөгчдийн холбоо |
| ТЕГ | Тагнуулын ерөнхий газар |
| УЕПГ | Улсын ерөнхий прокурорын газар |
| ТББ | төрийн бус байгууллага |
| ОУБ | олон улсын байгууллага |

## НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**Зорилго, зорилт.** Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн хандлага, 2021-2024 онд баримтлах стратегийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг гаргахад энэ төлөвлөгөөний зорилго оршино. Уг зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлж, төлөвлөгөөнд тусгалаа:

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний өнөөгийн тулгамдсан асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх, дүн шинжилгээ хийх;
- Хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээний хүрээг тодорхойлох мандатын шинжилгээ хийх, ерөнхий чиг үүрэг, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүргийг нарийвчлах;
- Эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж, давуу болон сул талыг эрэмбэлэх;
- Эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилт, уялдаа холбоо, нийтлэг асуудлыг судлах, хүрэх үр дүнг тооцох;
- Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хүрэх түвшин, үнэлэх шалгуур үзүүлэлтийг нарийвчлах;
- Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох;
- Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны уялдааг харуулах.

**Стратеги төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим.** Төлөвлөгөөг “Ухаалаг” (SMART) буюу зорилго тодорхой байх (S-Specific), хэмжиж болохуйц (M-Measureable), зорилгодоо хүрч болохуйц байх (A-Attainable), бодитой байх (R-Relevant), цаг хугацаатай байх (T-Time based) зарчмуудыг агуулсан байхаар боловсруулахыг зорьсон.

**Төлөвлөгөөний хамрах хүрээ.** Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, байгууллагын үйл ажиллагааг нэгдмэл байдлаар төлөвлөн 2021-2024 онуудад хэрэгжүүлэхээр тодорхойлов.

**Төлөвлөгөөг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн.** Энэхүү төлөвлөгөө нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, байгууллагын үйл ажиллагааг хооронд нь цогц байдлаар уялдуулан төлөвлөсөн баримт бичиг юм.

Уг төлөвлөгөө амжилттай хэрэгжсэнээр эдийн засгийн өсөлтийг дэмжсэн эрх зүйн шинэтгэл гүнзгийрч, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц бүрэлдэн, цахим засаглалыг хөгжүүлэх замаар хүн, нийгмийн амар тайван, аюулгүй байдал хангагдана.

Хууль зүй, дотоод хэргийн яам болон түүний харьяа агентлаг, байгууллагууд нь Монгол Улсын **1 сая 566 мянган км$^2$** газар нутагт, нийт **8252.658 км** урт хилийн шугамын дагуу, үүнээс хуурай газраар **7351.6 км**, усаар **901.058 км**, ОХУ-тай **3543 км**, БНХАУ-тай **4709.658 км** хиллэдэг хилийн шугам, Монгол Улсын **21** аймаг**, 329** сум**, 9** дүүрэгт үйл ажиллагаагаа явуулдаг нь энэ салбарын цар хүрээ өргөн, эрхлэх асуудал нь Монгол Улсын газар нутгийг бүрэн хамарсан байдгийн илэрхийлэл юм.

Зураг. Монгол Улсын газар нутгийн хэмжээ, хилийн шугамын урт




Өргөн уудам нутаг дэвсгэрийг хамарсан тус салбарын стратеги төлөвлөгөө боловсруулахад дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, туршлагыг судлах, хүртээмжтэй өсөлт, тасралтгүй хөгжилд чиглэсэн зорилтот түвшин, хүрэх үр дүнг тооцлоо. Бодлогын зорилт, үйл ажиллагааг тодорхойлохдоо ач холбогдлоор нь эрэмбэлэн, хэрэгжүүлэхэд гарч болох саад бэрхшээлүүдийг урьдчилан тооцож, хариу авах арга хэмжээг судалж, төлөвлөгөөнд тусгах зэрэг арга зүйг баримталсан болно. Үүнийг олон улсад хувилбарт төлөвлөлт (scenario planning)-ийн арга гэдэг.

Эрхлэх асуудлын хүрээний цар хүрээ, газар нутгийн хэмжээ, нутаг дэвсгэрийн онцлог, тархалт, нягтрал, байгаль цаг уурын байдал, нийгэм, эдийн засаг, улс төр, олон улсын чиг хандлага зэргээс хамаарч салбарын өмнө тулгарсан асуудлыг шийдвэрлэх арга зам нь төлөвлөлт юм.

Стратеги төлөвлөгөөг оновчтой, бодитой боловсруулахын тулд бид салбарын өмнө тулгамдсан асуудлыг дараах байдлаар тодорхойлж, ач холбогдлын зэрэглэлээр нь эрэмбэлэв.

## 1.1.САЛБАРЫН ӨМНӨ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

| *Тулгамдсан асуудлуудын эрэмбэ:* | | |
|---|---|---|
| **Нэн их** | **Их** | **Дунд** |
| **НЭГ.ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн дэвшилтэт техник, технологийг өргөнөөр нэвтрүүлэх, ашиглах нөхцөл бүрдүүлэх | Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай, хүртээмжтэй хүргэх, дэлхийн өндөр хөгжилтэй орны жишигт хүргэхэд чиглэсэн хөгжлийн зорилго, зорилтыг төлөвлөж, тодорхойлох | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэх |
| **ХОЁР.УЛСЫН ХИЛ ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Шинээр хилийн анги, салбар байгуулж, хилийн хэсгийг хуваан хариуцуулж, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх | Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах теле-камерын хяналтад хамруулах ажлыг зохион байгуулах | Үүрэн холбооны сүлжээ нэвтэрсэн газруудад мобайл VPN, сүлжээгүй газар өөрийн бие даасан шилэн кабель, радио релейн станцуудаар хилийн анги, салбаруудыг холбох |
| **ГУРАВ.ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын цогцолборыг шинээр барих | Орон нутагт шаардлага хангасан баривчлах байрыг үе шаттайгаар шинээр барих | Иргэний, захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, байгууллагын эрх зүйн байдлын зохицуулалтыг төрөлжүүлэн хуульчлах эсэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх |
| **ДӨРӨВ.УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотойгоор иргэн, хуулийн этгээдийг танихад Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилт, тоон гарын үсгийн хэрэглээ хангалтгүй | Улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай мэдээллийг төрийн байгууллагуудын мэдээллийн сангаас авах боломж бүрдээгүй | Засаг захиргааны нэгжид суурилсан хаяжилт нь нэгдсэн стандарт системгүй, ойлгомжгүй байгаа нь орчин үеийн бизнесийн болон төрийн үйлчилгээний шаардлага хангахгүй |
| **ТАВ.АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Төрийн архивууд архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх боломж бүрдээгүй | Мэргэжлийн боловсон хүчнийг бакалаврын түвшинд бэлтгэх тогтолцоо бүрдээгүй | Төрийн 37 архивын 32 нь архивын зориулалтын байргүй, хадгаламжийн сангийн багтаамж багатай |
| **ЗУРГАА.ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Гадаадын иргэдэд хяналт тавих механизм хангалтгүй | Хилийн боомт, орон нутаг дахь албан хаагчийн ажиллах, амьдрах нөхцөл хангалтгүй | Хилийн боомт, хил хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа, ахуй нөхцөлийг хангасан төрийн нэгдсэн бодлого байхгүй |
| **ДОЛОО.ОЮУНЫ ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Оюуны өмчийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага үүссэн. | Жижиг, дунд болон хөнгөн, хүнд үйлдвэр, үйлчилгээний салбарын шинийг санаачлагч, зохион бүтээгчид шинийг санаачлах, оюуны өмчийг ашиглах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах таатай орчныг бүрдүүлээгүй. | Оюуны өмчийн талаарх олон нийтийн мэдлэг, боловсрол хангалтгүй, оюуны өмчийг хүндлэх соёл нэвтрээгүй. |
| **НАЙМ.ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Шүүхийн шинжилгээ хийхтэй холбогдон үүсч байгаа харилцааг цогц байдлаар шийдвэрлээгүй | Гэмт хэргийн гаралтыг илрүүлэх, шинжилгээ хийх зориулалт бүхий техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг тогтмолжуулаагүй | Хүний нөөц хангалтгүй буюу шинжээчдийн орон тоо бага, нэг шинжээчид ногдох шинжилгээ, ажлын ачаалал их |
| **ЕС.ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Хууль зүйн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/119 дүгээр тушаалаар баталсан Хууль сахиулахын их сургууль /хуучнаар/-ийн | Сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд чанарыг эрхэмлэн шинэчлэл хийх, байгууллагын үнэт зүйл болох багш, судлаачдыг хөгжүүлэх, судалгаа хийх, сургалт явуулах арга зүй, чадавхыг сайжруулах, суралцагчдын эзэмших цогц чадамжийн түвшинг дээшлүүлэх, их сургуулийн хотхонд ажиллах, | |

| | | |
|---|---|---|
| хөгжлийн стратеги хөтөлбөр /2016-2025 он/-ийг шинэчлэх шаардлага үүссэн. | суралцах, хөгжих бүх талын хэрэгцээг хангасан таатай орчин нөхцөл бүрэн бүрдээгүй | |
| **АРАВ.ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Эрүүгийн хэргийн хохирогч болсон хүүхэд, төлбөрийн чадваргүй хохирогч, иргэний, захиргааны хэргийн зарим оролцогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааг үзүүлж эхлээгүй. | Төрийн албанд ажиллаж байгаа бусад албан хаагчийн адил улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тодорхой болгоогүй | Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа төрийн албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл тааруу. |
| **АРВАН НЭГ.ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЧИГЛЭЛЭЭР** | | |
| Салбарын хэмжээний эрдэм шинжилгээний байгууллагад албан хаагчдыг тогтмол сургах, гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад судалгаа хийлгэх бодит хэрэгцээ, шаардлага тулгарсан. | Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа эрх зүйн актын нэгдсэн сан бүхий хууль, эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn цахим хуудсыг орчин үеийн технологийн хөгжилд нийцүүлэн шинэчлээгүй. | Захиргааны ерөнхий хуулиар захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэснээс хойш 10 хоногийн дотор “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэх үүрэг хүлээсэн ба үйлдвэрт хэрэглэгдэж байгаа офсет машины ашиглалтын хугацаа дууссч цаашид засвар авах боломжгүй болсон. |
| **АРВАН ХОЁР.ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТАЛААР** | | |
| Эмч, эмнэлгийн ажиллагсдын нийгмийн баталгаа хангалтгүй, цалин бага байгаа зэргээс шалтгаалж тогтвор суурьшил муу. | Санхүү, эдийн засгийн боломж, материаллаг бааз дутагдалтай, эмнэлгийн төсвийн зардалд сургалт, судалгааны төсөв тусгагдаагүй. | Төгсөөд гарсан эмч мэргэжилтнүүдийн ажилдаа эзэн болох, богино хугацаанд амжилт бүтээл гаргах, бүтээлч сэтгэлгээ өрнүүлэх асуудал нийгмийн өнөөгийн шаардлагаас хоцрогдсон. |

## 1.2.СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа нийгмийн хэрэгцээ, шаардлагын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны стратегийн зорилго, зорилт, ач холбогдол өөрчлөгдөж байна. Хөгжлийн шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, чадавхыг бэхжүүлэх, эрх зүйн таатай орчныг бий болгох дараах хэрэгцээ, шаардлага үүссэн байна:

**Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хүрээнд:** Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх, шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, улмаар иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулахын тулд шүүх эрх мэдлийн байгууллагын эрх зүйн орчныг Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлж, олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

Шүүхийн шийдвэр гарцаагүй хэрэгждэг байх зарчмыг хэрэгжүүлэх, түүнчлэн олон улсын чиг хандлагад нийцүүлэн иргэний, захиргааны хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сайжруулах, мөн эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хорих ял эдэлж байгаа этгээдийг нийгэмшүүлэх, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн хөдөлмөрийн дадалд сурган, тодорхой хэмжээний орлого олох, уг орлогоос хохирлоо барагдуулах боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

**Хувийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд:** Бизнесийг дэмжсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээнээс үүдэн хувийн эрх зүйн салбарын хуулиудыг шинэчлэх цаг тулгараад байна. 2002 онд Иргэний хууль батлагдсантай холбогдуулан хувийн эрх зүйн салбарт дагаж мөрдөж байсан хуулиудыг тухайн үед нь уялдуулан шинэчилж байсан

хэдий ч эдийн засаг, бизнес, технологийн хурдацтай хөгжил нь хувийн эрх зүйн салбарын эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох хүлээлтийг бизнес эрхлэгчдэд үүсгээд байна.

Иймд хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг сайжруулан бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулж, баялаг бүтээгч, хувийн хэвшлийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна. Хувийн эрх зүйн чиглэлээр хийгдэх энэхүү эрх зүйн шинэтгэл нь эдийн засгийг сэргээх, өсөлтийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэлтийг дэмжих шинэтгэлийн суурь байхад томоохон түлхэц өгөх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэх юм.

**Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд:** Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгох зорилгоор Зөрчлийн тухай хуулиар оногдуулах торгох шийтгэлийн хэмжээг уян хатан байдлаар зохицуулах боломжийг судалж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

Эрүүгийн хууль дахь зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, Эрүү шүүлт тулгах, Хууль бусаар мөрдөн мөшгөх, Авлигын эсрэг гэмт хэргүүдэд оногдуулах ялын бодлогыг чангатгах;

Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах чиг үүрэг бүхий Мөрдөх албаны тогтолцоог боловсронгуй болгох;

Өнөөгийн хүн амын тоо, нягтрал, гэмт хэргийн гаралт, шүүхийн шинжилгээний хэрэгцээ, цар хүрээ, шинэ төрлийн болон тусгай шинжилгээний шаардлага зэргийг харгалзан шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоог өөрчилж, бүтэц, бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэн эрх зүйн статусыг тодорхой болгох, шинэ төрлийн шинжилгээний зохицуулалт, итгэмжилсэн шинжээчийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, санхүүгийн болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс учруулсан хохирол, түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг тооцох эрх зүйн орчныг тодорхой болгох;

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхтэй болон архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлэх, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах.

**Бусад шинэтгэлийн хүрээнд:** “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн эх газрын эрх зүйн бүлийн хэв шинж, философид суурилсан, бусад эрх зүйн бүлийн ололт, давуу талыг нутагшуулсан, Монгол Улсын язгуур ашиг сонирхолд нийцсэн, хүний эрхийг дээдэлсэн, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн урт хугацааны хөтөлбөрийг боловсруулах;

Гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн тэтгэмж тогтоолгохтой холбогдсон болон газар өмчлөх эрх нь хөндөгдсөн төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

Хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалт, хууль зүйн чиглэлийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион

байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлж, эдийн засаг, бизнесийн эрх зүйгээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх;

Хууль тогтоомжийн төсөл санаачлах хүрээ, хязгаарыг тодорхойлж, хуулийн төслийн боловсруулалтын чанарын үр нөлөөг дээшлүүлж, хуулийн хэрэгжилтийг үнэлэх, хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдээ, мэдээллээр хангах байнгын механизмыг бүрдүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх;

Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай, ил тод хүргэхэд чиглэсэн цахим шинэчлэлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулах;

Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, ил тод байдлыг хангаж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хангах тогтолцоог боловсронгуй болгох;

Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.2-т *"Төрийн албаны тухай хуулийн 53.1-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам нь тухайн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн стратеги төлөвлөгөөг дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулан төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна."* гэж заасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгагдсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилт, арга хэмжээнүүдийг 2021-2024 онд хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага үүссэн.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 156 дугаар тушаалаар баталсан "Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн стратеги хөтөлбөр"-ийг хэрэгжүүлсэн хэдий ч үр дүнг нь тооцолгүйгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар хүчингүй болгож, харьяа агентлаг, байгууллагуудын стратеги төлөвлөгөөг чиглэл тус бүрээр нь баталсан байна.

Иймд эдийн засгийн өсөлтийг дэмжих, төрийн үйлчилгээний ил тод, хүртээмжтэй цахим засаглалыг бэхжүүлэх, хүн, нийгмийн амар тайван, аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулаа.



УХА0677
9131517
116126271

## ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 350 дугаар тогтоолоороо баталсан “Төвлөрлийг сааруулах төрөөс баримтлах бодлого”, 2018 оны 22 дугаар тогтоолоороо баталсан “Төрийн байгууллагын чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын хүрээнд хийсэн салбарын чиг үүргийн шинжилгээн дээр үндэслэн мандатын шинжилгээг хийв.

Мандатын шинжилгээгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудал нь нийт 110 хууль, 24 олон улсын гэрээг хамарч байна.

Үүнээс Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах 28 хуулийн хүрээнд салбарын чиг үүргийг нарийвчлан тодорхойллоо.

Салбарын чиг үүргийг Хууль зүйн бодлого, Дотоод хэргийн бодлого гэсэн 2 ерөнхий чиг үүрэгт хувааж, үндсэн чиг үүрэг, дэд чиг үүрэг болон дараах байдлаар нарийвчлан тусгалаа.

| Салбарын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хуулийн тоо | | 110 хууль, 24 олон улсын гэрээ |
|---|---|---|
| Үүнээс | Тухайн салбарын хуулийн тоо | **82** |
| | Нийтлэг мөрддөг хуулийн тоо | **28** |

| **Ерөнхий чиг үүрэг-1: ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГО** | | |
|---|---|---|
| **Үндсэн чиг үүрэг** | **Дэд чиг үүрэг** | **Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид** |
| *ҮЧҮ-1: Хууль зүйн нэгдсэн бодлого* | *Хууль зүйн нэгдсэн бодлогоор хангах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх* | *ЗГХЭГ, яамд, агентлагууд, Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллага* |
| | *Хууль тогтоомжийг системчлэх санг эрхлэн хөтлөх, лавлагаа, мэдээллээр хангах* | |
| | *Захиргааны хэм хэмжээний актын бүртгэл, хяналтыг эрхлэх* | |
| | *Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх, лавлагаа, мэдээллээр хангах* | |
| *ҮЧҮ-2: Олон улсын гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого* | *Олон талт гэрээнд нэгдэн орох, тэдгээрт дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авах, хоёр талт гэрээ байгуулах болон тэдгээрийн хэрэгжилтийг хангах, Засгийн газарт холбогдох арбитрын маргаанд оролцох* | *ЗГХЭГ яамд, агентлаг, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага Дипломат төлөөлөгчдийн газрууд* |
| | *Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, зээл тусламжийн бодлогыг хэрэгжүүлэх* | |

| | | |
|---|---|---|
| *ҮЧҮ-3: Эрх зүйн шинэтгэлийн бодлого* | *Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх* | *ЗГХЭГ, яамд, агентлаг, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил* |
| | *Хууль тогтоомжийн төсөл боловсруулах* | |
| *ҮЧҮ-4: Хууль зүйн туслалцаа* | *Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх* | *ХЗҮХ, ХЗТТ, МХХ, МНТ, МӨХ, орон нутгийн хууль зүйн албад* |
| | *Эрх зүйн судалгаа, сургалт, сурталчилгаа хийх* | |
| | *Хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох асуудлаарх бодлогын хэрэгжилтийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх* | |
| | *Монголын хуульчдын холбоо, Монголын нотариатчдын танхим, нотариатч, орон нутгийн хууль зүйн албад, Монголын өмгөөлөгчдийн холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих* | |
| *ҮЧҮ-5: Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон бусад бүртгэл* | *Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлэх* | *УБЕГ* |
| *ҮЧҮ-6: Оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал* | *Оюуны өмчийн эрхийг хамгаалах, бүртгэх, баталгаажуулах* | *ОӨГ* |

## Ерөнхий чиг үүрэг-2: ДОТООД ХЭРГИЙН БОДЛОГО

| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
|---|---|---|
| *ҮЧҮ-1: Нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх* | *- Гэмт хэрэгтэй тэмцэх*<br>*- Нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах*<br>*- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах*<br>*- Улсын онц чухал, тусгай объектыг хамгаалах* | *ЦЕГ, ГХУСАЗЗ, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал* |
| *ҮЧҮ-2: Улсын хил хамгаалах* | *-Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах*<br>*-Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх*<br>*-Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх*<br>*-Цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөвлөгчийн арга хэмжээг хэрэгжүүлэх* | *ХХЕГ, ТЕГ* |

| | | |
|---|---|---|
| ҮЧҮ-3: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх | -Эрүү, иргэн, захиргааны зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах | ШШГЕГ, УЕПГ |
| ҮЧҮ-4: Шүүхийн шинжилгээ хийх | -Эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах | ШШҮХ |
| ҮЧҮ-5: Монгол Улсад орох, гарах, дамжин өнгөрөх, оршин суух, гадаадын иргэн, харьяатын асуудлыг эрхлэх | -Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журмын биелэлтийг зохион байгуулах<br><br>-Харьяатын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах | ГХЯ, ГИХГ, ХХЕГ, ЦЕГ |
| ҮЧҮ-6: Архивын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх | -Монгол Улс дахь үндэсний архивын сан хөмрөгийн баримтыг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, хяналт тавих, ашиглах болон албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах | АЕГ |
| ҮЧҮ-7: Салбарын албан хаагчдын боловсрол, эрүүл мэнд, хүний нөөц болон бусад нийгмийн баталгаа хангах | -Төрийн тусгай албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | ТТАХНЭ |
| | -Дотоод хэргийн салбарын албан хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, боловсон хүчнийг бэлтгэх | ДХИС |
| | -Салбарын менежмент, хүний нөөцийн хөгжлийн бодлогыг бэхжүүлэх | ХЗДХЯ |
| | -Салбарын албан хаагчдын нийгмийн асуудал, аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлогоор хангах | ХЗДХЯ |

## ГУРАВ.АЛСЫН ХАРАА-VISION

***Хүний эрх, эрх чөлөөг хангасан, амар тайван, хүмүүнлэг нийгмийг цогцлооно.***

## ДӨРӨВ.ЭРХЭМ ЗОРИЛГО-MISSION

*Үндэсний язгуур эрх ашиг, хүн, нийгмийн амар тайван байдлыг хадгалан хамгаалж, шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэн, иргэн төвтэй, тэгш хүртээмжтэй төрийн үйлчилгээг үзүүлнэ.*



УХА0577
9121317
1110120371

## ТАВ.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

**SWOT шинжилгээний арга зүй.** Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд салбарын SWOT шинжилгээг холбогдох судалгаа баримтад үндэслэн дараах ерөнхий арга зүйн хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

**Дотоод хүчин зүйл:** хөрөнгө, материал, ажиллах хүч, технологи, инноваци, чадавх, менежмент зэрэг салбарын дотоод боломжийн эерэг, сөрөг талыг нягтлан үзэж, одоогийн түвшин, цаашдын хөгжлийн хандлагыг тогтоох.

**Гадаад хүчин зүйл:** байгаль орчин, институц (төрийн бодлого, олон улсын болон, дотоодын хууль, журам, тогтсон заншил), дотоод, гадаад зах зээлийн төлөв байдал, өрсөлдөгч зэрэг салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх гадаад хүчин зүйлсийн таатай болон таагүй нөлөөг салбарын хэмжээнд тодорхойлох.

Салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх хамгийн чухал дотоод хүчин зүйлсийн давуу тал (Strenths-S) ба сул тал (Weakness-W), гадаад хүчин зүйлсийн боломж (Opportunities-O) ба аюул (Threats-T)-ын жагсаалтыг матрицаар нэгтгэн гаргасан.

SWOT шинжилгээний уламжлалт аргаар гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллийн үзүүлэлтүүдийн тоон бус утгаар ерөнхийд нь тодорхойлдог тул учир дутагдалтай юм. Иймд SWOT шинжилгээний илүү сайжруулсан хэлбэр болох шатлан судлах буюу AHP аргыг стратеги төлөвлөлтөд хэрэглэх нь илүү тохиромжтой гэж үзэн, сонгон авлаа.

**AHP (Analytic Hierarchy Process) шинжилгээ.** AHP шинжилгээ нь бүтэц, удирдлага, зохион байгуулалт, технологийн хувьд хоорондоо нарийн уялдаатай процессыг тэдгээрийн уялдааг нь харгалзан хүчин зүйл тус бүрийн эцсийн үр дүнд үзүүлэх нөлөөг тоон үзүүлэлтээр зангидан илэрхийлдэг арга юм.

Салбарын хөгжилд нөлөөлөх аливаа асуудлууд хоорондоо уялдаатай гадаад, дотоод олон хүчин зүйлсээс хамаарах ба тэдгээр хүчин зүйлс нь тоон болон шинж тэмдгээр илэрхийлэгдэх бөгөөд хэмжих нэгж нь харилцан адилгүй байна. Эдгээрийг нэг хэмжүүр буюу тоон хэмжүүрт шилжүүлж, хооронд нь жиших боломжтой болгох шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл, тоогоор үл илэрхийлэгдэх шинжтэй үзүүлэлтүүдийг тоон утгад шилжүүлж, тэдгээрийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд энэхүү аргыг хэрэглэдэг.

Тоогоор илэрхийлж, жишихдээ үнэлгээний хэр бодитой эсэхийг нийцтэй байдлын индекс буюу CI, нийцтэй байдлын харьцаа буюу CR илтгэлцүүрээр илэрхийлнэ. $CR<0.1$ байх нөхцөлд үнэлгээг зохистой болсон гэж үздэг.

Ийнхүү гадаад, дотоод хүчин зүйлсийг нягтлан тодорхойлж, үнэлсний үр дүнд салбарын үйл ажиллагаа бүрийн зорилго, хэрэгжүүлэх стратегийг дараах байдлаар тодорхойлно:

SO - шийдвэр: салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг дээд зэргээр ашиглах стратеги;



УХА0577
9131817
1116126371

WO - шийдвэр: салбарын сул талыг сайжруулан гадаад орчны таатай боломжийг дээд зэргээр ашиглах стратеги;

ST- шийдвэр: салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны таагүй нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах стратеги;

WT - шийдвэр: гадаад орчны таагүй нөхцөлд салбарын сул талаа сайжруулах замаар гарах сөрөг үр дагаврыг аль болох багасгах стратеги. Салбар тус бүрийн SWOT шинжилгээний үр дүнг доорх хүснэгтээр нэгтгэнэ.

**Салбарын SWOT шинжилгээ.** Хууль зүй, дотоод хэргийн салбарын дотоод хүчин зүйлд давуу талыг илэрхийлэх 6, сул талыг илэрхийлэх 6, гадаад хүчин зүйлсийн таатай нөхцөлийг илэрхийлэх 6, таагүй нөхцөлийг илэрхийлэх 6 гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан.

Тус салбарын 6 чухал дотоод хүчин зүйлсээс хамгийн их нөлөөтэй нь шинэ санал, санаачилга, технологи нэвтрүүлэхдээ удаан (23.6%), алба хаагчдын ажил үүргийн хуваарь жигд бус (18.4%), стратеги төлөвлөлт хангалтгүй (18%) зэрэг хүчин зүйлс тодорхойлогдсон байна.

Гадаад 6 хүчин зүйлсээс шийдвэрлэх нөлөө үзүүлэх нь нэг алба хаагчийн буруутай үйл ажиллагаанаас салбарын нэр хүнд унах эрсдэл (23.6%), нийгмийн цахим сүлжээ хараа хяналтгүй, ташаа, худал мэдээлэл тархсанаас үүдэн гарах эрсдэл (23%), иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байдаг нь үйл ажиллагаанд хүндрэл учруулдаг (18%) зэрэг нь шийдвэрлэх нөлөөтэйд тооцогдлоо.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний дотоод хүчин зүйлийн нийцтэй байдлын харьцаа нь CR=0.111, гадаад хүчин зүйлийнх CR=0.142 гарсан тул үнэлгээг үндэслэлтэй гэж үзлээ.

| **Дотоод хүчин зүйлс** | | **Гадаад хүчин зүйлс** | |
|---|---|---|---|
| **Давуу тал (S)** | **Сул тал (W)** | **Таатай нөхцөл (O)** | **Таагүй нөхцөл (T)** |
| 1.ХЗДХС-ын эрхлэх асуудлын цар хүрээ өргөн.<br>2.Салбарын дотоод үйл ажиллагааны дүрэм, журам, зааврын боловсруулалт, хэрэгжилт сайн .<br>3.Үйл ажиллагаа нь жигдэрсэн, тогтвортой.<br>4.Мэргэжлийн боловсон хүчнийг гадаад, дотоодын их сургуулиудад бэлтгэдэг.<br>5.Ажлын байрны орчин, нөхцөл сайн.<br>6.Албан хаагчдын нийгмийн асуудлыг шуурхай шийдвэрлэдэг. | 1.Стратеги төлөвлөлт хангалтгүй.<br>2.Шинэ санал, санаачилга, технологи нэвтрүүлэхдээ удаан.<br>3.Зарим ажлыг хэт шахуу хугацаанд хийдэг.<br>4.Алба хаагчдын ажил үүргийн хуваарь жигд бус.<br>5.Орон тоо дутмагаас ажлын ачаалал их.<br>6.Алба хаагчдын ажлыг дүгнэх, шагнал урамшуулал, албан тушаал дэвших, шинээр алба хаагч томилох, сонгон шалгаруулах асуудал нээлттэй биш. | 1.Хууль зүй, дотоод хэргийн салбарын бодлого, үйл ажиллагаанаас ард түмний хүлээлт их байдаг.<br>2.Эрх зүйн шинэтгэл, шийдвэр гаргах түвшний үйл ажиллагаа шуурхай явагддаг.<br>3.Нийгэмд нөлөөлөх нөлөөлөл их.<br>4.Гадаад, дотоод байгууллагуудтай харилцаа сайн.<br>5.Дотоод сүлжээнд холбогдож, мэдээлэл солилцож, түгээдэг болсон.<br>6.Эдийн засгийн таатай үед төсөв нэмэгдэх, цалин хөлс, нийгмийн асуудал зэрэгээр шийдэгдэх. | 1.Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг дутмаг байдал нь эрсдэл үүсгэдэг.<br>2.Нэг алба хаагчийн буруутай үйл ажиллагаанаас салбарын нэр хүнд унах эрсдэлтэй.<br>3.Нийгмийн цахим сүлжээ хараа хяналтгүй, ташаа, худал мэдээлэл тархсанаас үүдэн гарах эрсдэл их.<br>4.Нэгдсэн сүлжээг хөдөө орон нутагт хэрэглэхэд хүндрэлтэй, шийдвэрлэх асуудал ихтэй.<br>5.Урт болон дунд хугацаанд төлөвлөгдөөгүй, шинээр батлагдсан хууль, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зардал өсдөг.<br>6.Төрийн алба хаагчийн мэргэшсэн, тогтвортой байх зарчим алдагдсан. |

## Дотоод хүчин зүйлсийн үнэлгээний матриц:

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | 0.1 | 0 | 0.1 | 0.2 | 0.1 | 0.1 | **0.6** |
| | 0.166666667 | 0 | 0.166666667 | 0.333333333 | 0.166666667 | 0.166666667 | **0.139** |
| **2** | 0.1 | 0.2 | 0.1 | 0.2 | 0 | 0.1 | **0.7** |
| | 0.142857143 | 0.285714286 | 0.142857143 | 0.285714286 | 0 | 0.142857143 | **0.143** |
| **3** | 0.2 | 0.2 | 0.2 | 0.1 | 0.2 | 0.1 | **1** |
| | 0.2 | 0.2 | 0.2 | 0.1 | 0.2 | 0.1 | **0.15** |
| **4** | 0.1 | 0.1 | 0.2 | 0.2 | 0.2 | 0 | **0.8** |
| | 0.125 | 0.125 | 0.25 | 0.25 | 0.25 | 0 | **0.167** |
| **5** | 0.1 | 0.1 | 0 | 0.1 | 0 | 0.1 | **0.4** |
| | 0.25 | 0.25 | 0 | 0.25 | 0 | 0.25 | **0.125** |
| **6** | 0.1 | 0.1 | 0 | 0.1 | 0.1 | 0 | **0.4** |
| | 0.25 | 0.25 | 0 | 0.25 | 0.25 | 0 | **0.167** |

| | |
|---|---|
| **CI** | **0.65** |
| **CR** | **0.111** |

## Гадаад хүчин зүйлсийн үнэлгээний матриц:

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1** | 0.2 | 0.1 | 0.2 | 0.2 | 0.1 | 0.1 | **0.9** |
| | 0.222222222 | 0.111111111 | 0.222222222 | 0.222222222 | 0.111111111 | 0.111111111 | **0.16667** |
| **2** | 0.2 | 0.2 | 0.1 | 0.2 | 0.2 | 0.1 | **1** |
| | 0.2 | 0.2 | 0.1 | 0.2 | 0.2 | 0.1 | **0.16667** |
| **3** | 0.2 | 0.1 | 0.2 | 0.1 | 0.1 | 0.2 | **0.9** |
| | 0.222222222 | 0.111111111 | 0.222222222 | 0.111111111 | 0.111111111 | 0.222222222 | **0.16667** |
| **4** | 0.2 | 0.1 | 0.1 | 0.2 | 0.2 | 0.1 | **0.9** |
| | 0.222222222 | 0.111111111 | 0.111111111 | 0.222222222 | 0.222222222 | 0.111111111 | **0.16667** |
| **5** | 0.1 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.2 | 0.1 | **0.7** |
| | 0.142857143 | 0.142857143 | 0.142857143 | 0.142857143 | 0.285714286 | 0.142857143 | **0.16667** |
| **6** | 0.1 | 0.1 | 0 | 0.1 | 0.1 | 0.2 | **0.6** |
| | 0.166666667 | 0.166666667 | 0 | 0.166666667 | 0.166666667 | 0.333333333 | **0.16667** |

| | |
|---|---|
| **CI** | **0.65** |
| **CR** | **0.1483466** |

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

**Салбарын SWOT шинжилгээний үр дүн, баримтлах стратеги:**

| **SO** - салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны таатай боломжийг ашиглах стратеги | **WO** - салбарын сул талыг сайжруулан гадаад орчны таатай боломжийг ашиглах стратеги |
|---|---|
| - Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төлөвлөлтийг оновчтой хийх<br>- Олон улсын жишигт нийцүүлэн шинэ санал санаачилга, технологи нэвтрүүлэх<br>- Салбарын чадавх менежментийг сайжруулах<br>- Иргэдтэй харилцах болон байгууллага, албан хаагчдын хоорондын харилцааг зөв төлөвлөн зохион байгуулах | - Нийгэмд бүхэлдээ эерэг нөлөөллийг үзүүлэх бүх төрлийн ажлыг дэмжин хэрэгжүүлэх<br>- Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга, ил тод, хариуцлагатай, мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх,<br>- Төрийн үйлчилгээг цахимжуулах, шуурхай байдлыг хангах замаар хүртээмжийг нэмэгдүүлэх |
| **ST** - салбарын давуу талд тулгуурлан гадаад орчны таагүй нөлөөг даван туулах боломжийг ашиглах стратеги | **WT** - салбарын гадаад орчны таагүй нөхцөлд сул талаа сайжруулах замаар сөрөг үр дагаврыг даван туулах стратеги |
| - Хуулийн засаглалыг бэхжүүлж, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх<br>- Хуулиа сахин мөрддөг, биелүүлж хэрэгжүүлдэг ухамсар, дадлыг бий болгох ёс суртахууны хэв маягийг төлөвшүүлэн нийгэмд эрх тэгш байдал, шударга ёсыг тогтоох | - Иргэдэд хууль зүй, дотоод хэргийн салбарт итгэх итгэлийг төрүүлэх<br>- Иргэдийн хүсэл эрмэлзэл, санаа бодлыг үйл ажиллагаандаа тулгуур болгох<br>- Салбарын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлийн менежментийн тогтолцоог хөгжүүлэх |

## ЗУРГАА.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

### 6.1.Стратегийн зорилго

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилго нь эдийн засгийн өсөлтийг дэмжсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлж, мэргэшсэн, чадварлаг хүний нөөц, цахим засаглалыг хөгжүүлэх замаар хүн, нийгмийн амар тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд оршино.

### 6.2.Стратегийн зорилт

Стратегийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

6.2.1.Эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх, хүн-нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ.

6.2.2.Хүний эрх, эрх чөлөөг хангасан, хүртээмжтэй, хөгжилд түүчээлсэн дэд бүтцийг бэхжүүлнэ.

6.2.3.Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цахим шинэчлэлийг хэрэгжүүлнэ.



YXA0577
9131817
1115126371

6.2.4.Хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

6.2.5.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахуйц үр дүнтэй механизмыг нэвтрүүлнэ.

6.2.6.Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, салбарын санхүүгийн чадавх, менежмент, уялдааг сайжруулна.

Стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг хангахад Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах талуудын оролцоо, дэмжлэг, туслалцаа, уялдаа холбоо, харилцан хамтын ажиллагаа чухал билээ. Сайдын эрхлэх асуудлын хүрээний 2021-2024 оны стратегийн чиглэл, салбарын бүтцийн уялдаа холбоо, оролцогч талуудын хамаарал зэргийг цогц бүдүүвч, зураглалаар харуулав.



УХА0577
9131817
1116125371

| | | |
|---|---|---|
| ***Төлөвлөгөөг баталсан:*** | | ***Төсвийн ерөнхийлөн захирагч*** |
| ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД<br>/Албан тушаал/ | ……………………<br>/Гарын үсэг/ | /Х.НЯМБААТАР/ |
